



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/302

Булган сум

┌ Үр түүх байнгын болон түр талбай байгуулж ┐
арчлалт хийх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах төсөл арга хэмжээний 29,100,000 (хорин есөн сая нэг зуун мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах ажлыг зохион байгуулж, хавсралтад тусгагдсан арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг сум дундын Ойн ангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний "Сум дундын ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах (30га)" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



05 Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын 01 ний өдрийн 7/302 дугаар
захирамжийн хавсралт

Үр түүх байнгын болон түр талбай байгуулж
арчлалт хийх зардлын хуваарилалт

д/д	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг (төг)	Эрх шилжүүлсэн Ойн ангийн даргын нэр
1	2	3	4
1	Булган сум дундын Ойн анги	9,700,000	Б.Алтансүх
2	Хялганат сум дундын Ойн анги	9,700,000	М.Нямжаргал
3	Хутаг-Өндөр сум дундын Ойн анги	9,700,000	Ш.Даваахүү
	Нийт	29,100,000	